

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 <sup>23</sup> оны 10 сарын 13 ны өдөр

№ 19

Улаанбаатар хот

### *Салбар нэгжийн хаяг өөрчлөх тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн салбар, нэгж болох Дорнод салбарын албан ёсны оршин байгаа газрын хаягийг Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг Сити центр 07 тоот, Дорноговь салбарын албан ёсны оршин байгаа газрын хаягийг Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг Цахим үйлчилгээний төв 2 давхар, Улаанбаатар хот, Бөмбөгөр салбарын албан ёсны оршин байгаа газрын хаягийг Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 2-р хороо 40 50 мянгат, Бакула Ринбучийн гудамж 27/4 тоот, 5 давхар болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Компанийн салбар, нэгжийн хаяг өөрчлөгдөж буйтай холбоотойгоор компанийг төлөөлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэл, дүрэмд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



+

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20~~22~~<sup>23</sup> оны ~~10~~<sup>10</sup> сарын ~~13~~<sup>13</sup> -ны өдөр

№ ~~20~~<sup>20</sup>

Улаанбаатар хот

### *Гүйцэтгэх захиралд урамшуулал олгох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 07 тоот тогтоол, Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”ний 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 07 тоот тогтоолоор батлагдсан 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөний 3 дугаар улирлын гүйцэтгэлийг 101% хэмээн дүгнэсэн тул Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д түүнтэй байгуулсан гэрээний дагуу урамшууллыг 100% олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1-д заасны дагуу Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан дүнгээр урамшуулал олгохыг Ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Б.НАРАНБАТ



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 13-ны өдөр

№ 21.

Улаанбаатар хот

### *Бодлогын баримт бичиг батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн “Авлигын эсрэг бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. Компанийн “Авлигын эсрэг бодлого”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”, “Шүгэл үлээх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг тус тус баталж, үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.
3. Энхүү тогтоолын 1-д заасан баримт бичгийг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

